



ГАЗРЫН БОХИРДОЛЫН МОНИТОРИНГ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (Гачуурт орчмын нутгийн жишээн дээр)

ТӨСЛИЙН ТАЙЛАН

Нидерландын Засгийн Газрын Итгэлийн сангаас санхүүжиж,
Байгаль Орчны Яаманд хэрэгжиж буй
“Байгаль Орчны Шинэчлэл” төслийн хүрээнд гүйцэтгэв

УЛААНБААТАР 2006

ТӨСЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ МЭДЭЭЛЭЛ

Нидерландын Вант Улсын Засгийн газар Монголын байгаль орчны салбарын үйл ажиллагаа, чадавхийг дэмжих үүднээс Дэлхийн банкны дэргэд Итгэлийн сан байгуулан Монгол улсын Байгаль Орчны Яамтай хамтран “**Байгаль орчны шинэчлэл**” төслийг 2005-2006 онуудад хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хувь хүмүүст тэтгэлэг олгох уралдаант шалгалтыг хоёр дахь удаагаа зарлан явуулсан. Сонгон шалгаруулалтыг олон нийтэд ил тод зарлан явуулж, Монголд бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллага болон хувь хүмүүсийг төлөөлсөн 228 гаруй оролцогчдоос 33 төсөл шалгаруулсны нэгэнд доктор О.Батхишигтэй ахлагчтай судлаачдын багийн боловсруулсан “Газрын бохирдолын мониторинг, шалгуур үзүүлэлтүүд” сэдэвт төсөл шалгарсан. Нээлттэй Нийгэм Форум төслийг сонгон шалгаруулах, явцын үйл ажиллагаанд нь хяналт тавих үйл ажиллагааг хариуцаж ажиллаа. Тус форумын мэргэжилтэн Н.Эрдэнэсайхан төслийн үйл ажиллагаанд мониторинг, хяналт тавьж ажиллахын зэрэгцээ төслийн үр дүнг илүү бодитой болгох, стандарт боловсруулж батлуулах талаар үнэтэй санал, зөвлөмж өгч туслалцаа үзүүлсэнд гүн талархал илэрхийлж байна. Төслийг гүйцэтгэхэд бүх талын туслалцаа үзүүлсэн БОЯ, Нээлттэй нийгэм форум, Гачуурт тосгоны захиргаа, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Төв лаборатори, Улсын Стандартчилал Хэмжилзүйн Төв, ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгийн хамт олонд талархал илэрхийлж байна.

Багийн ахлагч:	Хөрс судлаач, газар зүйч	Др.	О.Батхишиг
Зөвлөх:	Хөрс судлаач,	Академич.	Д.Доржготов
Гүйцэтгэгчид:	Гачуурт тосгоны захирагч		Т.Төмөрбаатар
	Хөрс судлаач	Др.	Н.Нямсамбуу
	Газарзүйч		Д.Даваадорж
	Газар зохион байгуулагч		С.Сайнбаяр
	Хөрс судлаач		Б.Отгонтуяа
	МУИС, Хөрс судлалын ангийн оюутан		Ш.Дэлгэрсайхан
	МУИС, Хөрс судлалын ангийн оюутан		Ц.Болормаа

Харилцах утас: 99712339, 452054, 350472 Э-шуудан: batkhishig@gmail.com

Тулгамдсан асуудал.

Сүүлийн жилүүдэд хүний үйл ажиллагааны нөлөөллийн улмаас байгаль орчин өөрчлөлтөнд хөрс, ус агаарын бохирдол ихсэх хандлага ажиглагдаж ихэллээ. Ялангуяа Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг томоохон хотууд болон, алтны уурхай орчмын газрын хөрсөн бүрхэвч элэгдэлд эвдрэлд орохоос гадна янз бүрийн органик болон органик биш бодисоор бохирдож улмаар хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх боллоо.

БОЯ-ний Орчны шинжилгээний лаборатори, Улсын болон нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, ШУА-ийн Газарзүйн хүрээлэн, Физи технологийн хүрээлэн, хот аймаг дүүргийн байгаль орчны чиглэлийн мэргэжлийн хяналтын албад, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийдэг компаниуд нь тодорхой хэмжээгээр хөрсний бохирдлын судалгаа хийдэг боловч янз бүрийн арга зүйгээр, янз бүрийн чанарын түвшинд хийж гүйцэтгэж байна. Хөрсний бохирдлын хамгийн гол үзүүлэлтийн нэг болох хүнд металлуудын хүлцэх агууламж зэрэг **стандарт үзүүлэлтүүд Монгол орны хэмжээнд одоо болтол боловсрогдоогүй** ба судалгааны ажилдаа бусад орны стандарт үзүүлэлтүүдийг ашигласаар ирсэн. Бензипирен, диоксин, нефть бүтээгдэхүүнүүд, нүүрстөрөгчийн цагирагт нэгдлүүд зэрэг хөрсний янз бүрийн органик бохирдлуудын талаархи ойлголт мэдээлэл байгаль орчны төдийгүй мэргэжлийн байгуулаллагуудад өнөө хүртэл байхгүй байна.

Иймээс Монгол орны хөрсөн бүрхэвчийн онцлог шинжийг харгалзан үзсэн, олон улсын жишигт нийцсэн, хөрсний бохирдлын судалгааны иж бүрэн арга зүйг боловсруулах, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, нэгдсэн мониторингийн сүлжээ байгуулах үндэслэлийг боловсруулах шаардлагатай байна.

Төслийн үр дүнд шийдвэрлэсэн нь.

Бид “Газрын бохирдолын мониторинг, шалгуур үзүүлэлтүүд” төслийг хэрэгжүүлсний үр дүнд дараахь үр дүнд хүрлээ:

1. **“Газрын бохирдлын мониторинг, шалгуур үзүүлэлтүүд”** судалгааны арга зүй, аргачиллыг шинээр боловсрууллаа.
2. Монгол орны онцлог, нөхцөлд тохирсон газрын бохирдолын чиглэлийн 3 стандарт, хөрсний дээж бэлдэх стандартад оруулах өөрчлөлтийг боловсруулж, 2006 онд багтааж улсын стандартаар баглуулахаар Стандартчилал Хэмжилзүйн Төвтэй тохиролцон ажиллаж байна.
 - Газрын бохирдолын мониторингийн судалгааний арга зүй
Land pollution monitoring methods
 - Хот суурин газрын хатуу хог хаягдлын тархалтын үнэлгээ
Settlement area solid waste distribution assessment
 - Хөрсний хүнд металлын хүлцэх агууламж
Soil heavy metall maximum allowed content
3. Шинээр боловсруулсан арга зүйн дагуу **“Гачуурт орчмын нутийн газрын болхирдолын судалгаа”** явуулж, тайлан зөвлөмж боловсрууллаа.
4. **“Газрын бохирдлын мониторинг, шалгуур үзүүлэлтүүд”** сургалт семинарыг 2006.07.08-нд Гачуурт тосгонд зохион байгууллаа. Семинарт

газрын бохирдолын чиглэлийн мэргэжлийн байгууллагууд, Гачуурт тосгоны захиргааны ажилтнууд оролцож шинэ арга зүйтэй танилцсанаас гадна Монгол орны газрын бохирдолын тулгамдсан асуудлууд, судалгааны арга зүй, лабораторийн задлан шинжилгээний талаар санал солилцлоо. Гачуурт тосгон орчим газрын бохирдол ихтэй газруудаар явж хээрийн нөхцөлд үзүүлэх сургалт хийлээ.

5. Газрын бохирдолын асуудлыг олон нийтэд сурталчлах зорилгоор “Өдрийн сонин”-д “Хөрсний бохирдол” сэдэвт өгүүлэл бичиж, телевизээр ярилцлага, VCD хийлээ. Газрын бохирдолын талаар Гачуурт орчмын хүмүүсийн дунд санал асуулга явуулж, тайлан зөвлөмжинд тусгасан.

Ололттой сайн талууд.

- Газрын бохирдолын судалгааны арга зүй, стандартуудыг эмхэтгэж цэгцлэх, Монгол орны нөхцөлд тохирсон судалгааны арга зүйн анхдагч хувилбарыг боловсруулсан нь ололттой сайн тал.
- Газрын бохирдолын судалгааны арга зүй, стандарт 3-г улсын стандартаар батлуулахаар ярьж тохирлцсон байгаа нь үр дүнг хууль зүйн хувьд илүү баталгаатай болгож байна.
- Гачуурт орчмын газрын бохирдолын төлөв байдлыг 2006 оны байдлаар тодорхойлсон нь энэ нутгийн бохирдолыг бууруулах талаар хотын захиргаа дүүргээс тодорхой арга хэмжээ авах үндэслэл болж байна.
- Газрын бохирдолын чиглэлийн мэргэжлийн байгууллагууд цугларч ярилцаж санал бодлоо солилцсон нь цаашдын хамтын ажиллагаанд их үр өгөөжтэй болсон.
- Мэргэжлийн байгууллага болон захиргааны байгууллага энэхүү төсөлд хамтран нэг багийн гишүүд болон ажилласан нь үр дүнг, практикт хэрэгжүүлэх ашигтай хувилбар болсон.

Бэрхшээлүүд.

- Цаг хугацааны хувьд бага байсан. Уг төсөл доод тал нь 1 жилийн хугацаанд үргэлжилсэн бол илүү чанартай үр дүн гарах боломжтой байсан.
- 7-8-р сарууд нь бүх нийтийн амралтын улирал байсан учраас төр захиргааны байгууллагуудтай холбоотой ажлууд, лабораторийн задлан шинжилгээ зэрэг ажлууд удаашраах саадтай байсан.

Цаашид ижил төстэй үйл ажиллагаа явуулахад сургамж.

- Мэргэжлийн байгууллага болон төр захиргааны байгууллагын төлөөлөл нэг бага болон ажиллах хэлбэр илүү үр ашигтай бөгөөд цаашдын ижил төстэй төсөл хэрэгжүүлэхэд ийм зарчмыг баримтлах.
- Цаг хугацааны хүчин зүйл, төр захиргааны байгууллагуудын ажлын улирлын онцлогийг харгалзан төслийн үйл ажиллагааг төлөвлөх.

Гол дүгнэлтүүд.

Газрын бохирдолын мониторинг, шалгуур үзүүлэлтүүд төсөл нь зорилтоо бүрэн биелүүлсэн.

- Хөрсний бохирдолын чиглэлийн судалгааны арга зүй, стандартуудтай болсон.
- Төв орон нутгийн захиргааны байгууллагууд нь нарийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах талаар хангалтгүй байна. Хотын захиргаа, дүүргийн дэргэд эрдэм шинжилгээ судалгааны түр зөвлөл, хамтлаг ажиллаж тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлж байвал ажил илүү үр дүнтэй болно.
- Мэргэжлийн байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо сул байна. Цаашид нягт хамтран ажиллах шаардлагатай.
- Байгаль хамгаалахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд ард түмний дун санал асуулга явуулах, санал бодлыг сонсох, ухуулга сурталчилгааны бүх хэлбэрийг ашиглах. Телевиз, радио ашиглах боломж муутай монгол орны хөдөө орон нутгийн нөхцөлд айл өрх бүртэй уулзаж санал бодлыг нь сонсох, ярилцлага хийх нь илүү үр өгөөжтэй. Харин хот суурин газрын нөхцөлд телевиз, сонин хэвлэл зэрэг нийтийн мэдээллийн хэргслийг өргөн ашиглах шаардлагатай.
- Хөрсний бохирдолын стандарт, шалгуур үзүүлэлтүүд улсын хэмжээнд одоо болтол бүрэн гүйцэд батлагдаагүй байгаа нь тухайн газрын бохиролын төлөв байдлыг тогтооход хүндрэлтэй байна.
- Байгаль хамгаалах эрх зүйн орчин хангалттай байдаг боловч, амьдрал дээрх хэрэгжилт муу байна. Орон нутгийн олон нийтийн сайн дурын байгууллага, хамтлаг багуудыг дэмжих шаардлагатай.
- Холбогдох албан тушаалтнууд байгууллага олон нийтийн санал бодлыг сонсож ажиллах талаар хангалтгүй байна гэж үзэж байна. Тухайн газар нутгийн тулгамдсан асуудлыг тэр газар дээр нь амьдарч байгаа хүмүүсээс өөр хүн сайн мэдэхгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

Цаашдын үйл ажиллагааны санал.

- Газрын бохирдолын стандартыг 2006 онд багтааж улсын стандартаар батлуулах.
- Гачуурт тосгоны газрын бохирдолын мониторингийн хяналтыг жил бүр зохион байгуулж явуулж байх шаардлагатай байна.
- Гачуурт тосгоны газар зохион байгуулалтын төлөвлөгөө байхгүй хийгдээгүй байгаа учраас, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн газар зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах шаардлагатай.